

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Д/д	Нэр төрөл, үзүүлэлт	Шаардлага
1	Байршил	Улаангом 7-р баг – 2 худаг Худгийн байршлыг сумын ЗДТГазар тогтоон гүйцэтгэгчид мэдээллийг өгнө.
2	Материал	Бүх бараа материал, тоног төхөөрөмж нь шинэ, гарал үүслийн гэрчилгээтэй, чанарын сертификаттай баталгаатай байна. <ul style="list-style-type: none"> Цэвэр усны шугам, хоолой, тоног төхөөрөмж, тоноглолууд нь ундны усны зориулалтаар ашиглах шаардлага хангасан байх. Ус түгээх хоолой нь хэрэглэгчид ус авахад хүндрэлгүй, хүйтэнд хөлдөж хагардаггүй, уян чанартай байх.
3	Стандарт	Гэрээнд тусгагдсан бүх ажлыг Монгол улсад мөрдөж буй хууль тогтоомж, БНБД, стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.
Ухаалаг худгийн төхөөрөмжийн иж бүрдэл		
4	Удирдлагын товчлуур	<ul style="list-style-type: none"> Гаднаас хэрэглэгч шууд удирдах боломжтой, эвдрэлгүй, хэрэглэхэд хялбар, цельсийн -50°C-аас +45°C градууст хэвийн ажилладаг байх.
5	Карт	<ul style="list-style-type: none"> Дахин давтагдахгүй байх, ашиглаж буй серверт кодлогдож танигдах бөгөөд өөр төрлийн ямарч картаар усаа авах боломжгүйгээр хамгаалагдсан байна. Аймгийн төвийн худаг тус бүрт 350ш, хөдөө суманд сум тус бүрт 300ш карттай байна. Карт нь цэнэглэх боломжтой байна. Гүйцэтгэгч картын тоог нэмж болно.
6	Карт уншигч	<ul style="list-style-type: none"> 20см хүртэлх зайнаас усны картыг уншиж таних бөгөөд цонхны цаанаас ч уншиж хэрэглэгчийн мэдээллийг харуулах. (Унших хурд 42kbps-12Mbps). Уншигч өөр дээрээ хүйтнээс хамгаалсан ялтсан халаагуур суурилуулсан байх. Карт уншигч төхөөрөмж нь Монгол орны эрс тэс уур амьсгалд ажиллах чадвартай, сүүлийн үеийн бат бөх төхөөрөмж байна. Гадна талд суурилагдсан төхөөрөмж нь авах боломжгүй, бороо, цасны уснаас хамгаалагдсан байна.
7	Хэрэглэгчийн хяналтын дэлгэц	<ul style="list-style-type: none"> Хэрэглэгчид ойлгомжтой байх үүднээс гадна дэлгэцэнд хэрэглэгчийн талаарх мэдээлэл, картын дугаар, үлдэгдэл болон усны зарцуулалтын мэдээллийг харуулах бөгөөд усны зарцуулалт, үлдэгдлийн өөрчлөлтийг усаа авч байх агшинд харуулдаг байх. <p>Дэлгэцийн техникийн үзүүлэлт нь:</p> <ul style="list-style-type: none"> - Дэлгэцийн төрөл: LCD - Зураг төрөл: TFT - Дэлгэцийн нарийвчлал: 1280x800 Аудио USB 2.0 HDMI TV VGA оролттой байх шаардлагатай. Зураг видео гардаг байх.

8	Удирдлагын процессор	<ul style="list-style-type: none"> Мэдээлэл боловсруулалт хийх болон серверт холбогдох, худгийн төхөөрөмжийг удирдах тоноглол бүхий самбартай байх. Температурын болон хүчдэлийн өөрчлөлттэй үед ч ажиллагааны хэвийн горимт баазтай байх ба OFFLINE үед усаа түгээж ажиллах, ONLINE болсон үед автоматаар хэвийн горимд шилждэг байх. Худгийн систем өөр дээрээ SQLite 3.0 дээр хийгдсэн дотоод мэдээллээ төв серверт илгээдэг байх. Windows 7/8/10 үйлдлийн систем суудаг байх. Microsoft NET 4.5 болон түүнээс дээш хувилбар дээр хийгдсэн Desktop Form Applicatoin дэмждэг байх. Хэрэглэгчид Видео, Аудио мэдээлэл шууд хүргэх боломжтой байх.
9	Автомат хаалт	<ul style="list-style-type: none"> Хэвийн горимт нөхцөлд 2,5 сая литр ус нэвтрүүлэх ашиглалтын хугацаатай, ба үүнээс цааш ч ашиглах боломжтой олон улсын стандартыг хангасан бүтээгдэхүүн байх. (DN15-25mm Даралт 0-10кгс/см²)
10	Усны тоолуур	<ul style="list-style-type: none"> Монгол улсад ашиглахыг зөвшөөрсөн загварын туршилтад орсон, стандарт хэмжил зүйн байгууллагаар улсын баталгаажуулалтад хамрагдсан, 1 литрийн нарийвчлалтай хэмжүүр байна.
11	Барилга, дотор халаах хэрэгсэл, цахилгаан	<ul style="list-style-type: none"> Барилгыг ухаалаг тоолуур суурилуулах шаардлагад нийцүүлэн засварлах. Худгийн байрыг эрчим хүчний маш бага зарцуулалтаар, өрөөний температурыг мэдэрч температурыг тохируулах мэдрэгчтэй халаах хэрэгслээр халаах Дотор цахилгааны монтаж шинэчлэх, цахилгааны самбар угсрах
12	Дотоод сүлжээ	<ul style="list-style-type: none"> 3G болон 4G утасгүй интернет орчинд ажиллаж нууцлал бүхий дотоод сүлжээ үүсгэн худгийн үндсэн дата мэдээллийн санг төв сервер эсвэл бусад худагт илгээх боломжтой, сүлжээ доголдсон эсвэл тасарсан үед ч худаг хэвийн ажиллагаатай байх.
13	Програм хангамж	<ul style="list-style-type: none"> Програм хангамж нь усны хэрэглээ болон зарцуулалт, цэнэглэлтийн мэдээллийн сан үүсгэж серверт мэдээлэл боловсруулах анализ хийх график болон бусад тайлан гаргах боломжийг олгосон байх. Мөн нэг картаар аль ч худгаас ус авах боломжийг хэрэглэгчид олгох. Диспетчер дэлгэцээс худгуудын бүх мэдээллийг хянах боломжийг олгосон байх бөгөөд тухайн худгаар үйлчлүүлсэн хэрэглэгчийн тоо, худаг бүрийн усны зарцуулалт, аюулгүй ажиллагааны хэрэгслийн ажиллагааны байдал, худгийн температурын мэдээллийг харуулах бөгөөд худгуудын дотор, гадна камераар орчныг шууд харах, бичлэг ухрааж үзэх боломжтой байх.
14	Гадна гэрэлтүүлэг	<ul style="list-style-type: none"> Худаг орчмын 20м радиуст гэрэлтүүлэх бөгөөд цагийн тохиргоотой байх.
15	Хяналтын камер	<ul style="list-style-type: none"> Гадна, дотор хяналтын IP камер суурилуулах бөгөөд ONLINE горимд камерууд нь хөдөлгөөн мэдрэгчид тохируулагдсан 24 цагийн ажиллагаатай байна. Бичлэгийн 14 хоногийн мэдээллийг хадгалдаг байх.
16	Online сервер	<ul style="list-style-type: none"> Мэдээллийн нэгдсэн сан худгуудыг удирдлагаар хангах, гуравдагч системүүд холбогдох, худгуудаас мэдээлэл цуглуулах, хуваарилах зэргийг хийж гүйцэтгэх үүрэгтэй байх.

		<p>Мөн тайлан, статистик, динамик мэдээ тайлан боловсруулах мониторингийн системийн мэдээллээр хангах үүрэгтэй байх. Ашиглахад хялбар байх үүднээс диспетчерт усаа авч буй агшныг харуулах, зөөврийн худагтай бол ус дууссан талаарх мэдээллийг диспетчер харах боломжтой байх.</p>
17	Ашиглалтын заавар	<ul style="list-style-type: none">• Гадна хананд хэрэглэгчдэд зориулан харагдахуйц газар системийг ашиглан ус авах заавар, санамж болон анхааруулга тавих.• Тоног төхөөрөмжийн гэрчилгээ, каталоги, ашиглалтын заавар, бусад баримт бичгийг Монгол хэл дээр орчуулан ашиглагч байгууллагад хүлээлгэн өгөх.• Төхөөрөмжийг суурилуулж, ашиглах заавар, жигдрүүлэлт хийх.